



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 03 сарын 21 өдөр

Дугаар А08

Улаанбаатар хот

“Сити тур төсөл”-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 47 дугаар тогтоол, 2023 оны 111 дүгээр тогтоол, нийслэлийн Засаг даргын 2022 оны А/155 дугаар захирамжаар батлагдсан Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдын хэрэгцээнд нийцсэн хотын аяллын бүтээгдэхүүн, шинэлэг үйлчилгээг бий болгох, гадаад дотоодын жуулчдын сонирхлыг татах арга хэмжээний тоог нэмэгдүүлэх, нийслэл Улаанбаатар хотын түүх, соёл, аялал жуулчлалын үзмэрүүд, хотын хөгжилтэй танилцуулах зорилгоор “Сити тур төсөл”-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлсүгэй.

2. “Сити тур төсөл”-ийг хэрэгжүүлэх төсвийг хавсралтаар баталж үйл ажиллагаанд шаардагдах зардал 70,000,000 (далан сая) төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Агентлаг хариуцсан Ахлах нягтлан бодогч (Д.Уянга)-д зөвшөөрсүгэй.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг танилцуулж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийн хэлтэс (С.Туул)-т даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

23
Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2024 оны 03 сарын 20-ний өдрийн
108 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



“СИТИ ТУР” ТӨСЛИЙН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСВИЙН ЗАДАРГАА

2024 оны 03 дугаар сарын 20-ний өдөр

Улаанбаатар хот

№	Зарцуулалт	Тоо ширхэг	Нэгж дүн /төгрөг/	Нийт дүн /төгрөг/
1	Аяллын хөтчийн цалин	1 хүн*5сар	1,500,000₮	7,500,000₮
2	Маркетинг сурталчилгаа /Сити тур аялалын танилцуулга боршур/	2168ш	2,000₮	4,336,000₮
3	Жолоочийн цалин	2 хүн*7 сар /сард 12удаагийн гаралт/	2,000,000₮	28,000,000₮
4	Шатахууны зардал	2 автобус* 2,046л	3,910₮	16,000,000₮
5	Тос масло, угаалга цэвэрлэгээ, татвар, засвар, нэмэлт үйлчилгээ	2	4,082,000₮	8,164,000₮
6	Гражийн төлбөр /11сарын01-ний өдрөөс 03 сарын 30-нийг хүртэл нийт 182 хоног/	2	3,000,000₮	6,000,000₮
НИЙТ				70,000,000₮